ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | | |
| 1.1 | “Алсын хараа 2050” бодлогын баримт тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | |
| 1.1.1 | Хүүхдийн сэргийлж болох эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, нялхасын болон 5 хүртлэх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах. | Улсын төсөв | 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин | 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин-2.1 | 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин-1.9 | Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 11 сарын статистик мэдээгээр ногдох 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэглийн түвшин 1000 амьд төрөлтөд 0.7 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,4 промилээр буурсан үзүүлэлтэй байна.<br>2025 оны тав хүртэлх насны хүүхдийн эндэглийн байдалд дүн шинжилгээ хийж сэргийлж болох эндэгдэл нөлөөлөх хүчин зүйлийг судалж дараах ажлуудыг зохион байгуулан ажиллалаа. Үүнд:<br>- Хүүхдийн яаралтай тусламж, эрэмбэлэн ангилалт<br>- Хүүхдийн өвчний цогц менежмент<br>- Нярайн амьсгал гачаал хам шинж<br>- Дутуу нярайн халдвар<br>- Нярайн гипокси-ишемийн шалтгаант энцефалопати<br>- Дутуу нярайн менежмент<br>- Хүүхдэд тохиолдох томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх арга, эмнэл зүйн заавар<br>- Бага насны хүүхдийг осол гэмтлээс сэргийлье<br>- Хүүхдийн НУУР (нүдний угийн улаан рефлекс)-ийн үзлэг зохион байгуулах<br>- Тохиолдолд суурилсан сургалт | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зэрэг эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулж. Эрүүл мэндийн байгууллагуудын 286 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг (давхардсан тоогоор) хамруулсан байна. Мөн ажил сайжруулах чиглэлээр 3 удаагийн зөвлөмжийг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. | |
| 1.2 | МУ-ын таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | |
| 1.2.1 | Эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог тусгай хуваарийн дагуу хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан хэлбэрээр зохион байгуулж, хамралтыг нэмэгдүүлэх. | ОНТ, 10 сая | Илрүүлэг үзлэгийн хамралтын хувь. | Илрүүлэг үзлэгийн хамралтын хувь-43.2 | Илрүүлэг үзлэгийн хамралтын хувь -47.5 | "Эрүүл Булган" хөтөлбөрийг боловсруулан Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн VI/32 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд сургуульд суурилсан 1 дүгээр ангийн 6 настай сурагчдын нүд, шүд, зүрхний эмгэгийг эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгийн явц аймгийн хэмжээнд 2025 онд нүдний анхан шатны үзлэгийн хамрагдалт 98,2%, шүдний үзлэгийн хамрагдалт 95%, зүрхний үзлэгийн хамрагдалт 96,2%-тай байна. Анхан шатны илрүүлгээр 150 хүүхэд нүд, 534 хүүхэд шүд, 62 хүүхэд зүрхний өөрчлөлтэй илэрсэн бөгөөд эдгээр хүүхдүүдийг дараагын шатны оношилгоо, эмчилгээнд хамруулж, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг эрчимжүүлж байна. Мөн халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгт аймгийн НЭ-ийн дэмжих төвөөр 1111 иргэн, явуулын баг буюу нарийн мэргэжлийн эмчийн үзлэг оношилгоонд 2885 иргэн, нийт 3996 иргэнийг эрт илрүүлэг үзлэгт хамруулсан. "Эрүүл шүд" хөтөлбөрийн хүрээнд 18 хүртэлх насны хүүхдийн шүд, амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах, үзлэг, эмчилгээ, зөвлөгөө өгөхөөр Япон-Азийн эрүүл мэндийг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дэмжих байгууллага, “Ц.Бадрал” сан, АШУИС-ийн Нүүр ам судлалын сургууль, Булган аймгийн нэгдсэн эмнэлгийн шүдний кабинетын эмч нар хамтран үзлэг зохион байгуулж, 170 хүүхдэд шүдний үзлэг, зөвлөгөө, эмчилгээг хийгдснээс тусгай хэрэгцээт 4 хүүхдэд шүдний тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Улсын гуравдугаар төв эмнэлэг, МҮОНРТ, ХААН Банк сангийн хамтран хэрэгжүүлж буй “Цусны даралт ихсэлтийн эсрэг аян–2025” аян зохион байгуулагдаж 1034 иргэнийг зүрх судасны өвчлөл, цусны даралт ихсэлтийн эрсдэлийн үнэлгээ, нарийн мэргэжлийн үзлэг оношилгоонд хамруулсан. Эдгээр илрүүлэг үзлэгүүдийн дүнгээр аймгийн хэмжээнд эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 50.5%-д хүрч, өмнөх оноос 7.3%-иар өссөн байна. | |
| 1.3 | МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | |
| 1.3.1 | “Элэг бүтэн Монгол” арга хэмжээг эрчимжүүлэх | * | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Төлөвлөгөөни й хэрэгжилтийн хувь-90 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-95 | Элэг бүтэн арга хэмжээг эрчимжүүлэн, эрт илрүүлэг үзлэгт нийт хамрагдвал зохих иргэдийн 25,5 хувийг буюу 10163 иргэнийг гепатитын В, С вирус илрүүлэх оношилгоонд хамруулж гепатитын С вирусийн архаг халдварын шинэ 8 тохиолдол, В вирусийн архаг халдварын шинэ 7 тохиолдлыг илрүүлж, вирусийн ачаалал тодорхойлох шинжилгээнд хамруулж 16 иргэнийг эмчилгээнд хамруулсан.<br>Аймгийн хэмжээнд Д вирусын халдвартай иргэдийн судалгааг гаргаж, ХӨСҮТ-д хүргүүлсэн.<br>ЭМГ-ын даргын 2025 оны А/13 дугаар тушаалаар “Хавдрын эсрэг хамтдаа” 6 сарын аяныг аймгийн хэмжээнд зарлан, 31 заалт бүхий төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтийг боловсруулан ЭМБ-дад | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүргүүлсэн. В вирусын сайн дурын дархлаажуулалтыг эрчимжүүлэн нийт 3989 иргэнийг дархлаажуулсан.<br>“Хавдрын өвчлөлийг бууруулахад таны, миний оролцоо” сэдвээр төрийн болон төрийн бус 6 байгууллагын 136 иргэнд, эрүүл мэндийн 9 байгууллагын 63 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан байна. | |
| 1.3.2 | Иргэдэд тэнцвэртэй хооллолт, хоол хүнсний зөв хэрэглээг таниулах мэдээлэл сургалт, сурталчилгааны нөлөөллийн ажлыг зохион байгуулах. | Улсын төсөв | Сургалтын тоо-<br>Сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо-<br>Цахим орчинд байршуулсан мэдээллийн тоо- | • Сургалтын тоо - 10<br>• Сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо - 2400<br>• Цахим орчинд байршуулсан мэдээллийн тоо 48 | • Сургалтын тоо-14<br>• Сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо-2700<br>• Цахим орчинд байршуулах мэдээллийн тоо 52 | “Тэнцвэртэй хооллолт”, “Эрүүл бус хүнсний хэрэглээ” сургалтыг 22 удаа зохион байгуулж, боловсролын 5 байгууллагын 187, хүчний байгууллагын 80 албан хаагч, эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлсэн 10153 иргэнд зохион байгуулсан.<br>Эрүүл Монгол хүн, НЭМТ-өөс зарласан “САХАРГҮЙ 30 ХОНОГ CHALLENGE”-д нэгдэж аймгийн хэмжээнд “ДОЛОО ХОНОГИЙН НЭГ ӨДРИЙГ ЧИХЭРТЭЙ” арга хэмжээний удирдамжийг ЭМБ-ууд, ЕБС-уудад хүргүүлж, “Сахарын хэрэглээнээс татгалзая”, “Сахарын хэрэглээ” зэрэг 7 төрлийн постор, 3 төрлийн видео бичлэгийг хүргүүлсэнээр 350 гаруй хүүхдэд чихэр, сахарын хэт их хэрэглээний талаар мэдээлэл сурталчилгааг СӨБ, ЕБС-ийн сурагчдад хийсэн. Сургуульд суурилсан 6 настнуудын эрт илрүүлэг үзлэгт хамрагдах 1057 суралцагчид эрүүл хооллолт, чихрийн хэрэглээний талаар мэдээлэл өгч 700 гаруй сурталчилгааны материал тараасан. Нийт 15142 иргэнд сургалт мэдээлэл хийсэн байна. | 100% |
| 1.3.3 | Эрүүл мэндэд эрсдэл үүсгэж байгаа хүчин зүйлс, архи, тамхины хэрэглээний талаархи иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийн мэдээлэл, | Улсын төсөв | Сургалтын тоо<br>Сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо<br>Цахим орчинд байршуулсан мэдээллийн тоо | • Сургалтын тоо - 5<br>• Сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо - 2500 | • Сургалтын тоо- 8<br>• Сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо-3000<br>• Цахим орчинд байршуулах | Аймгийн Засаг даргын 2015 оны А/32 тоот захирамжаар “Архи тамхи-Шинэ үеийн сонголт биш”, “Эрүүл хооллолт-Эрүүл амьдралын үндэс” нэрэмжит сарын аяныг жил бүрийн 2, 3-р сард Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж хэвшээд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сургалт, сурталчилгааг өргөжүүлэх. | | | • Цахим орчинд байршуулсан мэдээллийн тоо 48 | мэдээллийн тоо 52 | байна. Тус сарын аяны хүрээнд хорт зуршил, эрүүл хооллолт, дасгал хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх талаар 20 удаагийн сургалтаар 3315 ЕБС-ийн сурагчид болон иргэдийг хамруулж, 6 төрлийн 2500 гаруй сурталчилгааны материал тараасан.<br>Булган Эрүүл мэндийн газар нүүр цахим хуудсаар хорт зуршил, буруу хооллолт, хөдөлгөөний хомсдол тархалалт, стресс зэрэг шалтгаан зэрэг сэдвээр 6 төрлийн зөвлөмжит мэдээллийг давхардсан тоогоор 23 удаа цахим хуудсан байршуулж, 12365 иргэн цахим хуудсанд хандсан.<br>Жил бүрийн тавдугаар сарын 31-нийг "Дэлхийн тамхигүй өдөр" болгон тэмдэглэж, дэлхий даяар тамхинаас үүдэлтэй өвчлөл, нас баралт, хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжиж ажилладаг. Энэ жил "Тамхины үнэнг илчилье" уриатайгаар тэмдэглэн өнгөрүүлж, үйлчилгээний газруудыг тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдан борлуулахгүй байх санаачилга, уриалгыг хүргүүлэн ажилласан. | |
| 1.4 | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | |
| 1.4.1 | Нас, сэтгэхүйн онцлогт тохирсон контент, мэдээллийг бэлтгэн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг цахимаар түгээн дэлгэрүүлэх. | 10,0 | Телевизийн ярилцлага, нэвтрүүлэг, контент, сурталчилгааны тоо- | Телевизийн ярилцлага-2, нэвтрүүлэг-4, контент-3, сурталчилгаа-10 удаа | Телевизийн ярилцлага- 4 , нэвтрүүлэг- 6, контент-5 сурталчилгаа-14 удаа | Эрүүл мэндийн боловсрол олгох, иргэдэд мэдээлэл түгээх зорилгоор дараах агуулгатай телевизийн контент, нэвтэрүүлгийг бэлтгэн ажилласан. Үүнд: Хамтарсан нэвтрүүлгийн хүрээнд:<br>• “Анхдагч зөвлөгөө” нэвтрүүлэг – 6 удаа<br>• “Миний мэргэжил сайхан” баримтат нэвтрүүлэг – 8 удаа<br>• Анимэйшн контент – 16 ширхэг<br>• Видео шторк – 3 ширхэг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ингэснээр нийтдээ олон нийтийн эрүүл мэндийн боловсролд чиглэсэн **33 контент** бэлтгэн хүргэлээ.<br>Мөн Эрүүл мэндийн газрын албан ёсны цахим хаяг www.bu.mohs.gov.mn болон “Булган Эрүүл мэндийн газар” нүүр хуудас, бусад цахим сувгуудаар мэдээллийг тогтмол байршуулж ажиллав. Эрүүл мэндийн байгууллагууд давхардсан тоогоор **252 мэдээлэл** байршуулж, нийт **47,684 иргэн** цахим хуудсанд хандсан бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс **4.2 хувиар өссөн.** | |
| 1.4.2 | Хорт зуршил, буруу хооллолт, хөдөлгөөний хомсдол зэрэг анхдагч эрсдэлт хүчин зүйлийг бууруулах мэдээлэл, сургалт, сурталчилгааны хамрах хүрээг нэмэгдүүлэх. | 10,0 | Хамрагдсан хүн амын тоо- | 14000 | 15000 | Аймгийн Засаг даргын 2015 оны А/32 тоот захирамжаар “Архи тамхи-Шинэ үеийн сонголт биш”, “Эрүүл хооллолт-Эрүүл амьдралын үндэс” нэрэмжит сарын аяныг жил бүрийн 2, 3-р сард Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж хэвшээд байна. Тус сарын аяны хүрээнд хорт зуршил, эрүүл хооллолт, дасгал хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх талаар 20 удаагийн сургалтаар 3315 ЕБС-ийн сурагчид болон иргэдийг хамруулж, 6 төрлийн 2500 гаруй сурталчилгааны материал тараасан.<br>Булган Эрүүл мэндийн газар нүүр цахим хуудсаар хорт зуршил, буруу хооллолт, хөдөлгөөний хомсдол таргалалт, стресс зэрэг шалтгаан зэрэг сэдвээр 6 төрлийн зөвлөмжит мэдээллийг давхардсан тоогоор 23 удаа цахим хуудсан байршуулж, 12365 иргэн цахим хуудсанд хандсан.<br>Жил бүрийн тавдугаар сарын 31-нийг "Дэлхийн тамхигүй өдөр" болгон тэмдэглэж, дэлхий даяар тамхинаас үүдэлтэй өвчлөл, нас баралт, хөгжлийн | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бэрхшээлтэй болох эрсдэлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжиж ажилладаг. Энэ жил "Тамхины үнэнг илчилье" уриатайгаар тэмдэглэн өнгөрүүлж, үйлчилгээний газруудыг тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдан борлуулахгүй байх санаачилга, уриалгыг хүргүүлэн ажилласан. | |
| 1.4.3 | Ундны ус, сүү сүүн бүтээгдэхүүнийг хадгалах зориулалтын савны хэрэглээг нэмэгдүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах. | 20,0 | Өрхийн тоо | 0 | 4000 | Малчдын эрүүл мэндийг дэмжихээр хөдөөгийн малчин, мал бүхий 1917 өрхийн 2904 иргэнд ундны ус, сүү сүүн бүтээгдэхүүнийг хадгалах зориулалтын савны хэрэглээний талаарх мэдээлэл, сургалт сурталчилгааг хийж, ундны усны савны тэмдэг тэдэглэгээний талаар гарын авлага боршурыг бэлтгэн 1500 ширхэгийг тараасан. Сэлэнгэ сумын нийт айл өрхийн 35% ундны усандаа зориулалтын сав хэрэглэж байна. Могод сум “Хөх савнаас-Хөхүүрт шилжье” уриалгыг малчин айл өрхүүддээ гарган ажиллаж байна. Эрүүл мэндийн байгууллагууд “Өөрчлөлтийг өөрөөсөө эхэлье” уриалгыг гаргаж хүнсний хэрэгцээндээ хуванцар сав хэрэглэхээс бүрэн татгалзаад байна. мэдээлэл сурталталгаа нөлөөллийн ажлыг зохион байгуулсанаар айл өрхүүд айрагны саваа уламжлалт хөхүүр буюу үхрийн ширээр солих арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. | 90% |
| 1.4.4 | Иргэдэд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн гаж нөлөө, эрсдлээс сэргийлэх сургалт нөлөөлийн ажлыг зохион байгуулах. | - | Сургалтын тоо | Зохион байгуулсан сургалтын тоо -2 | 4 | “Эмийн зохистой хэрэглээ”-г төлөвшүүлэх зорилгоор “Хүн амын эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх нь”, ”Эмийн жор цахимаар бичих, олгох” “Бичил биетний тэсвэржилтийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ” зэрэг сургалтыг 4 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 20 эрүүл мэндийн байгууллагын 306 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөн эрүүл мэндийн байгууллагуудын эмч нарын дунд энгийн эмийн цахим жорын аян зохион байгуулж үр дүнг тооцож улсын хэмжээнд 4-р байр эзэлсэн. ”Эмийн жорын маягт, жор бичилт” MNS 5376:2016 6.1-д зааснаар эмийн жорын хяналтыг сайжруулах, жор бичилтийг бүртгэх, жорын дагуу эм худалдан авах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор 13 сумын эрүүл мэндийн төв, 32 эмийн санд мэргэжил арга зүйгээр хангаж, зөвлөн тусалж тухай бүрд зөвлөмж хүргүүлж хэрэгжилтийг 84%-тай хангуулан ажиллаж байна.<br>Эдгээр эрүүл мэндийн байгууллагууд нь 951 иргэн, 1460 хэвтэн эмчлүүлэгч, 1510 ширхэг тараах материалыг тарааж эмийн зохистой хэрэглээг сурталчилсан байна.<br>2025 оны 11 сарын байдлаар Булган аймгийн хэмжээнд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх зөвшөөрөлтэй 29 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 1 эм ханган нийлүүлэх байгууллага, 6 Эмийн сан, 14 сумын эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангаж, зөвлөн тусалж тухай бүрд зөвлөмж хүргүүлж хэрэгжилтийг 82%-тай хангуулан ажиллаж байна.<br>Мөн улирал бүр мансууруулах болон ЭМС-ын 2015 оны 68 тоот тушаал “Сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам”-ын дагуу эрүүл мэндийн байгууллагуудын тайлан нэгтгэж ЭЭХХЗГ-т хүргүүлж ажиллаж байна. | 100 |
| 1.4.5 | Олон нийтийн эрүүл мэндийн ажилтан, үе тэнгийн зөвлөгчдийг | 10,0 | Сургалтын тоо<br>Хамрагдсан ОНЭМА, үе тэнгийн зөвлөгчийн тоо | Сургалтын тоо-1<br>ОНЭМА- 70 | Сургалтын тоо-2<br>ОНЭМА- 140<br>Үе тэнгийн зөвлөгч | Аймгийн хэмжээнд 145 олон нийтийн эрүүл мэндийн ажилтан идэвхтэй үйл ажиллагаа явуулж, халдварт болон | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | чадавхижуулж, бэлтгэх. | | | Үе тэнгийн зөвлөгч - 0 | - 20 | халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 21 удаагийн арга хэмжээг зохион байгуулсан нь иргэдийн эрүүл мэндийн боловсрол, дадалд эерэг өөрчлөлт авчирсан үр дүнтэй ажил болсон байна. Булган аймгийн Эрүүл мэндийн газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран “Олон нийтийн эрүүл мэндийн ажилтан, нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудыг чадавхжуулах нь” сургалтыг цахим болон танхимаар 2 удаа зохион байгуулж, нийт ЭМБ-уудын 26 нийгмийн эрүүл мэндийн ажилтнууд, орон нутгийн давхардсан тоогоор нийт 183 ОНЭМА -уудыг чадавхжуулсан.<br>Өсвөр үеийнхний дунд эрүүл мэндийн зөв дадлыг төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд 60 үе тэнгийн зөвлөгчийг бэлтгэн чадавхжуулж, хамтран ажиллаж байна.<br>“Булганы сэргэлт – Эрүүл Булган” хөтөлбөрийн санхүүжилтээр “Дархлаажуулалтын үйл ажиллагаанд олон нийтийн эрүүл мэндийн ажилтны оролцоог бэхжүүлэх нь” сэдэвт сургалтыг амжилттай зохион байгууллаа. Уг сургалтыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Булган аймгийн ЗДТГ, Эрүүл мэндийн газар хамтран зохион байгуулж, аймгийн 16 сумын ӨЭМТ-ийн 95 олон нийтийн эрүүл мэндийн ажилтнууд хамрагдлаа.<br>Үе тэнгийн зөвлөгч нартай хамтран “24/3 – Шүдээ зөв угаа-2025” аяны хүрээнд амны хөндийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх сургалтыг 28 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургуульд зохион байгуулж, нийт 1240 эцэг эх, асран хамгаалагч хамрагдаж, 6 сургууль “Шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээн” дотооддоо зохион байгуулсан нь үр дүнтэй үйл ажиллагаа болсон байна. | |
| 1.4.6 | Ерөнхий боловсролын сургуульд "Шүд угаах цаг" бий болгон хэвшүүлж, амны хөндийн эрүүл ахуй сахих сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах. | 15,0 | Шүдээ угааж хэвшсэн ангийн тоо | 53 | 73 | Эрүүл шүд арга хэмжээг аймгийн хэмжээнд эрчимжүүлэн 2024 оноос ЕБС-ийн бага ангийн суралцагсад үдийн цайны дараа шүд угаах цагийг бий болгож, шүдээ угааж эхэлсэн.<br>“Шүд угаах цаг” зохион байгуулах зөвлөмж бичлэгийг Сайхан Монгол тв-тэй хамтран бэлтгэж цахим сургалтыг ЭМБ-ын дарга, нийгмийн ажилтан, ЕБС-ийн захирал, нийгмийн ажилтан, эмч нарт зохион байгуулсан. Сургалтаар эцэг эх, сурагчид, багш нарын амны хөндийн эрүүл мэндийг сахих, хамгаалах мэдлэг чадварыг нэмэгдүүлсэн. Шүд арга хэмжээний хүрээнд "Шүд угаалтын аварга шалгаруулах" тэмцээн зохион байгуулан, 21 сургуулийн 144 хүүхэд оролцсон.<br>ЕБС-ын үдийн цай хөтөлбөрийн дараа шүд угаах цагийг 104 ангид бий болгосон.<br>24/3-Шүдээ зөв угаа-2025 аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулан, амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 6470 хүүхдийг хамруулж, 3449 хүүхдэд нэмэлт эрдэсжүүлэлт хийсэн.<br>Аяны турш амны хөндийн эрүүл мэндийн талаарх зөвлөмжит ведио контент 3, зөвлөмж мэдээлэл 5 төрлийг бэлтгэн Эрүүл мэндийн газар болон бүх шатны Эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудсаар мэдээлж, нийгмийн сүлжээ олон нийтийн мэдээллийн хэрэгслээр иргэд олон нийтэд түгээсэн.<br>Мөн аймгийн шүдний эмч мэргэжилтний | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | холбооноос “Амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох” мэдээллийг бэлтгэн аймгийн хэмжээнд нэгдсэн нэг сургалтын гарын авлагаар сургалт мэдээллийг зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд нийт 35 удаагийн сургалт зохион багуулж, 3100 гаруй иргэдийг хамруулсан. | |
| 1.4.7 | Аймгийн Засаг даргын нэрэмжит зүрх судас, хоол боловсруулах, хавдрын чиглэлээр нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг сум, багийн түвшинд зохион байгуулах | 60,0 | Үзлэг зохион байгуулсан сумдын тоо | Нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг 9 сум, 1 тосгонд зохион байгуулсан. | 16 сум, 1 тосгонд | Аймгийн Засаг даргын нэрэмжит нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг Баян-Агт, Бугат, Сайхан, Сэлэнгэ, Тэшиг, Хутаг-Өндөр, Баяннуур, Гурванбулаг, Дашинчилэн, Рашаант зэрэг 10 суманд 7 чиглэлээр зохион байгуулагдсан. Нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт дотор 470, сүрьеэ 502, рентген 382, халдварт 37, мэдрэл 227, эмэгтэйчүүд 271, шүд урьдчилан сэргийлэх үзлэгт 900, С, В вирус илрүүлэг шинжилгээ 58, В вирусын дархлаажуулалт 14, ДОХ тэмбүү 24 хүнд үзлэг хийж, нийт 2885 иргэнийг хамруулж, зөвлөгөө өгч, сургалт, мэдээлэл хийж ажилласан байна. Үзлэгээр 68 иргэнд шүдний эмчилгээ хийж, харьяа эрүүл мэндийн төвд 3 иргэнийг хэвтүүлж, 19 иргэнийг лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад илгээсэн байна. | 90% |
| 1.4.8 | Сүрьеэ, БЗДХ/ХДХВ өвчнийг эрт илрүүлэх үзлэг зохион байгуулж, илэрсэн өвчлөлийг эмчлэн эдгэрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах | 5,0 | Илрүүлэгт хамрагдсан иргэдийн тоо | Сүрьеэгийн идэвхитэй илрүүлэгт хамрагдсан тоо-601 БЗДХ/ХДХВ илрүүлгийн тоо- 3959 | Сүрьеэ-610 БЗДХ/ХДХВ илрүүлгийн тоо-4000 | Сүрьеэ илрүүлэх үзлэг, оношилгоог Баян-Агт, Баяннуур,Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн, Могод,, Тэшиг, Хутаг, Сэлэнгэ, Бугат, Хангал, Хялганат тосгонд зохион байгуулан 1657 хүнийг хамруулаа. Үзлэгт хамрагдсан иргэдийн 99%-ийг рентген шилжилгээнд хамруулан, 79 иргэний гэрт очиж айлаас айлд тусламж үйлчилгээг үзүүллээ. Эрт илрүүлэг үзлэгээр 4 өвчлөл шинээр илрүүлэн, эмчилж, 3 сэжигтэй тохиолдлыг илрүүлэн давтан шинжилгээнд хамрууллаа. 2025 онд БЗДХ-ын 52 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 10 тохиолдлоор буурсан байна. Эрүүл мэндийн байгууллагууд БЗДХ, ДОХ/ХДХВ илрүүлэх түргэвчилсэн шинжилгээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлж хэвтэн эмчлүүлэгчид, жирэмсэн, сайн дураараа шинжилгээ өгч буй иргэд, нийт 2836 иргэнийг шинжилгээнд хамруулан, илэрсэн өвчлөлийг эмчлэн эдгэрүүлсэн байна. | |
| 1.4.9 | Эрүүл мэндийн байгууллагуудын шүдний кабинетийн үйл ажиллагааг тогтмолжуулж, шүдний цоорлыг бүрэн эмчлэн эрүүлжүүлэх | 45,0 | Байгуулсан шүдний кабинетийн тоо | Баян-агт, Сайхан, Хутаг-өндөр, Хишиг-өндөр сумын эрүүл мэндийн төвүүдэд кабинетийн үйл ажиллагааг тогтмолжсон. | Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн сумын ЭМТ | Дашинчилэн сумын Эрүүл мэндийн төв улсын төсвийн 20 сая хөрөнгө оруулалтаар шүдний кабинетэд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр болон хүний нөөцөөр хангагдаж иргэдэд амны хөндийн тусламж үйлчилгээг тогтмол үзүүлж байна.<br>Гурванбулаг сумын эрүүл мэндийн төв шүдний эмчээр хангагдсан, тоног төхөөрөмжийн хангалт дутмаг. Бүрэгхангай ЭМТ тоног төхөөрөмжөөр хангагдсан, хүний нөөц хангагдаагүй байна. | 70% |
| | | | Шүд нь бүрэн эрүүлжсэн хүүхдийн тоо | 5100 | 5680 | ЭМС, БС-ын хамтарсан 2024 А/413, А/151 дугаар тушаалаар хийгдэж байгаа ЕБС-ын 1-р ангийн суралцагсдад хийхдээ амны хөндийн эрүүл мэндийн үзлэгт аймгийн хэмжээний 1004 хүүхдийг хамруулж, 10-р сарын 30-ны байдлаар эмчлэн эрүүлжүүлэлт 93.2%-тай явагдаж байна. Аймгийн нэгдсэн эмнэлгийн шүдний кабенит 9 сарын байдлаар урьдчилан сэргийлэх үзлэг зөвлөгөө мэдээллийг 22077 иргэнд үзүүлж, 16190 хүнийг эмчилгээнд хамруулсан байна. Гурванбулаг, Тэшиг Мишээл сантай хамтран зохион байгуулсан үзлэгт 1-18 насны 1381 хүүхдийг хамруулж, 2999 шүдийг эмчлэн | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрүүлжүүлсэн. Тус үзлэгээр 1-18 настай хүүхдийн дундах цоорлын эмчим буюу ЦЛАШ индек 4,2 байгаа боловч 1-5 насны шүүн шүдэнд 6,4, 12-17 насны байнгын шүдэнд 4,8 буюу цоорлын эрчим хамгийн өндөр байна. "Эрүүл шүд" хөтөлбөрийн хүрээнд 18 хүртэлх насны хүүхдийн шүд, амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах, үзлэг, эмчилгээ, зөвлөгөө өгөхөөр Япон-Азийн эрүүл мэндийг дэмжих байгууллага, "Ц.Бадрал" сан, АШУИС-ийн Нүүр ам судлалын сургууль, Булган аймгийн нэгдсэн эмнэлгийн шүдний кабинетын эмч нар хамтран үзлэг зохион байгуулж,170 хүүхдэд шүдний үзлэг, зөвлөгөө, эмчилгээг хийгдсэн. үүнээс тусгай хэрэгцээт 4 хүүхдэд шүдний тусламж үйлчилгээ үзүүлсэн. | |
| 1.4.10 | ЭМБ-уудад оношилгоо, эмчилгээний дэвшилтэт арга технологи нэвтрүүлж, иргэдийн чирэгдлийг багасгах | | Дэвшилтэт технологийн тоо | 3 | 7 | ЭМБ-уудад оношилгоо, эмчилгээний дэвшилтэт арга технологи 6 шинээр нэвтрүүлсэнээр лавлагаа шатлалын эмнэлэгт илгээх иргэд өмнөх оноос 6 хувиар буурсан. 1. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Лабораторийн тасагт оношилгоо, шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлж цусанд 8 хүнд фосфор, папиллома вирусийн илрүүлэх шинжилгээнд 63 эмэгтэй хамрагдсанаас 11 эмэгтэйд өөрчлөлт илрэн нарийн мэргэжлийн эмчийн хяналтад авч, шаардлагатай зөвлөгөө, зөвлөмж, эмчилгээ болон давтан хяналтыг тасралтгүй үргэлжлүүлж байна. Гель картын аргаар 5 удаа шинжилгээ хийж хувийн тохиргоо, ургийн хромосомын гажгийн эрт илрүүлэг "Хоёрол" тестийн шинжилгээ 10 үзсэн. 2. Чих хамар хоолойн чиглэлээр хамрын хагалгаа, хэнгэрэг нөхөх дурангийн мэс заслыг нэвтрүүлж, "Ринопластик" мэс засал 11 хүнд хийж, Япон аргачлалаар дурангаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 6 хүнд хэнгэрэг нөхсөн 3. Урологи андрологийн дурангийн мэс заслын эмчилгээг нэвтрүүлж нутагшуулснаар түрүү булчирхай -10, давсгийн чулуу -3 тохиолдлыг мэс засал хийсэн. 4. Анхан шатны бүх эрүүл мэндийн байгууллага хүүхдийн зүрхний цахилгаан бичлэгийн аппратаар хангагдсан. Сургуульд суурилсан 6 настны эрт илрүүлгийн үзлэгээр 1017 хүүхдийг зүрхний цахилгаан бичлэгт хамруулж өөрчлөлттэй гарсан 210 хүүхдээс 174 хүүхдийг лавлагаа шатлалын эмнэлэгт илгээж нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулан, хяналтад авсан. 5. Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн эмч нар болон анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын 23 эмчийг хүүхдийн хараа шалгах сургалтанд хамруулж, хүүхдийн хараа шалгах багажаар ханган 0-16 насны 1446 хүүхдийг нүдний хараа шалган үзлэгт хамруулсанаас 284 хүүхдэд нүдний эмгэг илэрч дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлсэн. 6. Төрөх, эмэгтэйчүүдийн тасагт нярайн зүрхний төрөлхийн гажгийн эрт илрүүлэг, гүйцэт болон дутуу нярайн нүдний эмгэг илрүүлэг үзлэгийг нэвтрүүлж дутуу нярайн ретинопатийн илрүүлэг үзлэг 7 хүүхэд хамруулж үүнээс 1 хүүхэд ДНР оношлогдож, лавлагаа шатлалын эмнэлэгт илгээсэн. | |
| 1.4.11 | Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг “CERVICARI AI” аппаратаар умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамруулах | 15,0 | Хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо | 1200 | 1400 | Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг хиймэл оюун ухаан суурилсан “CERVICARI AI” аппаратаар умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг, үзлэгийг Могод, Баяннуур, Дашинчилэн, Рашаант, Гурванбулаг, Хутаг-Өндөр сумдад зохион байгуулж нийт 334 эмэгтэйг үзлэгт хамруулсан.<br>Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 11 сарын байдлаар **нийт 694** эмэгтэйг | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үзлэгт хамруулсан. Үүнээс хэвийн 493, эс болон эдийн шинжилгээ өгөх шаардлагатай 200 эмэгтэйг илрүүлсэн.<br>Шаардлагатай эмэгтэйчүүдээс эсийн шинжилгээнд 125, эдийн шинжилгээнд 10 эмэгтэйг хамруулж. Эдийн шинжилгээний үр дүнгээр 4 эмэгтэйд LEEP эмчилгээ хийж, мөн 4 эмэгтэйг нарийн мэргэжлийн эмчийн хяналтад авч 6 сар тутам хяналтын үзлэгт хамруулан ажиллаж байна. 2 шинжилгээний хариу хүлээгдэж байна. | |
| 1.4.12 | Эрүүл мэндийн байгууллагуудын барилгын засвар үйлчилгээг үе шаттай хийж гүйцэтгэх. | 1055.0 | Барилгын засвар үйлчилгээ хийгдсэн байгууллагын тоо- | 3 | Барилгын засвар үйлчилгээ хийгдсэн байгууллагын тоо-3 | Орон нутгийн 2025 оны төсвийн 1055.0 сая төгрөгийн санхүүжилтаар дараах эрүүл мэндийн байгууллагуудын барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллалаа. Үүнд: Аймгийн Нэгдсэн эмнэлгийн барилгын Б блокийн хэсгийн засварын ажлыг 350.0 сая төгрөгөөр “Гурван Уулын Хишиг” ХХК, Хангал сумын ЭМТ-ийн барилгын засварын ажлын энэ оны гүйцэтгэлд 305.0 сая төгрөгөөр “Соотон Чоно” ХХК, Тэшиг сумын ЭМТ-ийн барилгын засварын ажлын энэ оны гүйцэтгэлд 400.0 сая төгрөгөөр “Бүлээн Оргил” ХХК тус тус гүйцэтгэж бүрэн ашиглалтанд хүлээн авсан. | 100 |
| 1.4.13 | Эрүүл мэндийн байгууллагуудын тусгай хэрэгцээт тоног төхөөрөмж, инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн ажлыг үе шаттай хийж гүйцэтгэх. | 472.0 | Инженерийн шугам сүлжээнд холбогдсон байгууллагын тоо-<br>Суурилуулагдсан лифтний тоо | 1 | Төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдсон барилгын тоо-3<br>Суурилуулагдсан лифтний тоо-2 | Орон нутгийн 2025 оны төсөвт гурван сумдын эрүүл мэндийн байгууллагуудын барилгыг төвлөрсөн шугам сүлжээнд холбоход шаардлагатай 472 сая төгрөг, аймгийн Нэгдсэн эмнэлгийн 50 ортой төрөх эмэгтэйчүүдийн тасаг, 160 ортой эмнэлгийн барилгад тус бүр 1 лифт угсарч суурилуулахад шаардлагатай 400.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тус тус батлуулж, дараах ажлуудын гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллалаа. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Орон нутгийн төсвийн 68.0 сая төгрөгийн санхүүжилтаар Сайхан сумын ЭМТ-ийн 2 барилга ариутгах татуургын төвлөрсөн шугамд холбогдсон. Орон нутгийн төсвийн 104.0 сая төгрөгийн санхүүжилтаар Могод сумын ЭМТ-ийн морго, гражийн барилга ариутгах татуурга, цэвэр усны шугамд холбогдсон. Мөн орон нутгийн төсвийн 300.0 сая төгрөгийн санхүүжилтаар Булган сумын “Эмийн цэцэглэн” ӨЭМТ-ийн барилга төвлөрсөн дулаан, цэвэр усны шугамд холбогдсон. Нэгдсэн эмнэлгийн 2 барилгад лифт угсарч суурилуулах ажлыг 400.0 сая төгрөгөөр “Оакс инженеринг” ХХК тус тус гүйцэтгэлээ. Дээрх ажлуудын гүйцэтгэлд ГХБХБГ, зураг төсвийн зөвлөх байгууллагуудтай хамтран ажиллаж барилгын ажлуудыг 100% хүлээн авсан. | |
| 1.4.14 | Эрүүл мэндийн байгууллагуудын барилгын зураг, төсөв боловсруулж батлуулах. | 20.0 | Батлагдсан зураг төсвийн тоо- | 0 | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн рентгений өрөө, хүлээн авах эрчимт эмчилгээний тасаг, мэс заслын тасгийн барилгын их засварын зураг, төсөв батлагдсан байна. | Орон нутгийн төсвийн санхүүжилтаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн рентген оношилгоо, яаралтай тусламж, хүлээн авах гемодиализ сэхээн амьдруулах тасгийн барилгын их засварын ажлын зураг, төсвийг Улаанбаатар хотын "Аслаан" ХХК -иар гүйцэтгүүлж, барилгын засварын ажлын нийт төсөвт өртөг болох 399.7 сая төгрөгийг 2026 оны орон нутгийн төсөвт тусган батлуулав. Улсын төсвийн 103.0 сая төгрөгийн санхүүжилтаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн 100 ортой шинэ эмнэлгийн барилгын холболтын зураг төсөв зохиох ажлыг Ньюкон ХХК-аар гүйцэтгүүлж, зураг төсвийг хүлээн авсан. Шинэ барилга барихтай холбоотойгоор аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэдрэл, мэс засал, сэтгэцийн тасгуудад их засварын зураг, төсөв боловсруулах ажлыг зогсоосон. | 100 |
| 1.4.15 | Эрүүл мэндийн | 360.0 | Парк шинэчлэлт хийгдсэн | Аймгийн | Гурванбулаг, | Хандив тусламжийн 25.0 сая төгрөгийн | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагуудыг түргэн тусламжийн автомашинаар үе шаттай хангах. | | автомашины тоо- | Нэгдсэн эмнэлэг-2, сумдын Эрүүл мэндийн төвүүд 11 автомашинаар хангагдсан. | Бүрэгхангай, Хутаг-өндөр, Орхон сумдын Эрүүл мэндийн байгууллагууд түргэн тусламжийн автомашинаар хангагдана. | санхүүжилтаар Баян-Агт сумын ЭМТ-д Probox маркийн түргэн тусламжийн авто машинаар хангагдсан. Орон нутгийн 2026 оны төсөвт Бүрэгхангай, Орхон сумдын эрүүл мэндийн байгууллагуудад түргэн тусламжийн автомашины 160.0 сая төгрөг батлагдсан. Гурванбулаг, Хутаг-Өндөр сумдын Эрүүл мэндийн байгууллагуудын автомашины санхүүжилтийг Эрүүл мэндийн сайдын багцаас шийдвэрлүүлэх хүсэлтийг хүргүүлсэн. | |
| 1.4.16 | Эрүүл мэндийн салбарын эмнэлгийн тоног төхөөрөмжийн стандарт хангалтыг нэмэгдүүлэх. | 160.0 | Эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тоног төхөөрөмжийн стандарт хангалтын хувь- | 90 | Эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тоног төхөөрөмжийн стандарт хангалтыг 92%-д хүргэнэ. | Улс, орон нутгийн төсвийн нийт 837.4 сая төгрөгийн санхүүжилтаар эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалт нэмэгдэж эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмжийн стандарт хангалт өмнөх оноос 3.2 хувиар нэмэгдлээ. Тухайлбал: Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 192.0 сая төгрөгийн санхүүжилтээр 16 сумын эрүүл мэндийн төвийг 8 нэр төрлийн 16 ширхэг Мобайл технологийн төхөөрөмжөөр хангасан. Улсын төсвийн 126.0 сая төгрөгийн санхүүжилтээр хүүхдийн тусламж үйлчилгээнд шаардлагатай зүрхний цахилгаан бичлэгийн аппаратыг 16 сум, 1 тосгоны 18 эрүүл мэндийн төв, Сайхан сумын ЭМТ-д 35.0 сая төгрөгийн ЭХО аппарат, аймгийн нэгдсэн эмнэлэгт 30 ширхэг тэргэнцэр, нярайн шарлалтын аппарат, Сэлэнгэ сумын ЭМТ-д 5.5 сая төгрөгийн шүдний эмчилгээний багаж, Тэшиг сумын ЭМТ-ийн шүдний кабинетыг 5.0 сая төгрөгийу багаж хэрэгслээр тус тус хангалаа. Орон нутгийн төсвийн 160.0 сая төгрөгийн санхүүжилтээр аймгийн Нэгдсэн эмнэлэгт гемодиализын 2 аппарат, шүдний тоног төхөөрөмж 2 ширхэгийг тус тус суурилуулснаар эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмжийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хангалт 93.2 хувьд хүрч суурь түвшнээс 3.2 пунктээр нэмэгдсэн байна. | |
| 1.4.17 | "Эрүүл Булган" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 150,0 | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 0 | 70% | "Эрүүл Булган" хөтөлбөрийг боловсруулан Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн VI/32 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Хорт хавдар илрүүлэх үзлэг, шинжилгээнд 6474 хүнийг хамруулж, онош батлагдсан иргэдийн 24,7%-ийг эрт илрүүлэн эмчилгээнд хамруулсан. Сургуульд суурилсан 1 дүгээр ангийн 6 настай сурагчдын 98,2%-ийг нүдний анхан шатны үзлэгт, 95,0%-ийг шүдний үзлэгт, 96,2%-ийг зүрхний эмгэгийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. “Шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан. Тэмцээнд ЕБС-ийн эрүүл мэндийн хичээл заадаг багш, эмч, 4-7 ангийн сурагчид, Сум, өрхийн ЭМТ-ийн эмчлэгч эмч, шүдний эмч, арга зүйч нарыг хамруулсан. Тэмцээнд нийт 17 сургуулийн 18 баг 8 хүүхдийн бүрэлдэхүүнтэй нийт 144 хүүхэд оролцож, мэдлэг, чадвараа нэмэгдүүлсэн. Сайхан-Монгол TV-тэй хамтран 3–5 минутын 16 контентоор дамжуулан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сар бүр олон нийтэд түгээн сурталчилсан. Олон нийтийн эрүүл мэндийн 145 ажилтан идэвхтэй үйл ажиллагаа явуулж, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 21 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, иргэдийн эрүүл мэндийн боловсрол, дадалд эерэг өөрчлөлт авчирсан үр дүнтэй ажил болсон. | 95 |
| 1.4.18 | Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах үндсэн болон | - | Хамрагдсан эмч, мэргэжилтний тоо | 2021-2024 онд нийт 46 эмнэлгийн | 2025-16<br>2026-14<br>2027-14 | Эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2025 онд хүүхэд судлал, дүрс | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төрөлжсөн мэргэшил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах | | | мэргэжилтэн | 2028-14 Нийт -58 | оношилгоо, мэдээгүйжүүлэг, хавдрын хими, дотоод шүүрэл, зүрх судас, бүдүүн шулуун гэдэс, нярай, яаралтай тусламж, эмэгтэйчүүдийн хавдрын мэс засал, эм найруулах, нийгмийн эрүүл мэндийн сувилахуй, эрүүл мэндийн бүртгэл мэдээлэл, хавдрын сувилахуй, яаралтай тусламжийн сувилахуй, эх барих, лаборатори, хөнгөвчлөх зэрэг 20 чиглэлээр 22 эмч, сувилагч, тусгай мэргэжилтнүүд төгсөлтийн дараах 3 сараас 2 жил хүртэлх хугацааны үндсэн болон төрөлжсөн, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан. | |
| 1.4.19 | Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг багаар нь өндөр хөгжилтэй оронд урт болон богино хэмжээний сургалтад хамруулж, туршлага судлуулах | 130,0 | Сургалтанд хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо- | 2021-2024 онд нийт 19 эмнэлгийн мэргэжилтэ н | 26 | Өндөр хөгжилтэй оронд эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургах, мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор эрүүл мэндийн удирдлага, хүний нөөц, чих хамар хоолой, нүдний өвчин судлал, анхан шат, дүрс оношилгоо, шүд, зүрх судлал зэрэг 8 чиглэлээр БНСУ, БНХАУ, БНЭУ, Казакстан зэрэг 4 улсад 19 их эмч, эмнэлгийн мэргэжилтэн богино хугацааны сургалтад хамрагдаад байна. Эдгээр суралцагчдын зардлыг улсын төсөв, орон нутгийн хөтөлбөрийн санхүүжилт, "Бадрал сан", суралцагч хувиасаа гаргах зэрэг эх үүсвэрүүдээс шийдвэрлэсэн. | 90 |
| 1.4.20 | Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллахад орон нутгийн дэмжлэг урамшуулал үзүүлэх | 70,0 | Дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагаа | 1 | 4 | Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор улс, орон нутгийн төсвөөс 392.0 сая төгрөгийг зарцуулж, 20 албан хаагчдад зуслангийн газар олгож, 20 албан хаагчид амьдрах байраар хангах, 10 албан хаагчид орон байрны түрээсд дэмжлэг үзүүлэх, 5 албан хаагчид цахилгаан, дулааны төлбөр, 5 албан | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хаагчид өвлийн идэш зэрэг бодит дэмжлэг үзүүлж, 419 албан хаагчийг илрүүлэг үзлэгт хамруулсан. Үүнд:<br>-Бүрэгхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2 эмнэлгийн мэргэжилтэнг орон сууцаар хангасан. Мөн Эрүүл мэндийн төвийн хуучин байранд засвар хийж сэргээн 3 мэргэжилтэнг амьдрах орон байраар хангасан.<br><br>-Бугат сумын 2 эмнэлгийн мэргэжилтэнг байгууллагын сүрлэн эмнэлэгт байрлуулан халаалт, цахилгааны зардлыг байгууллага шийдвэрлэдэг.<br><br>-Дашинчилэн сумын Орон нутгийн хөгжлийн сангаас 30 сая төгрөг шийдвэрлүүлэн 1 их эмчийг зөөврийн орон сууцаар хангасан.<br><br>-Могод сумын ЭМТ-д шинээр төгсөж ирсэн 1 их эмчийг байр орон сууцаар хангаж, хоол хүнсний туслалцааг ЭМТ-өөс тухай бүр хангадаг.<br>-Сэлэнгэ сумын эрүүл мэндийн төвийн 20 албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлж зуслангийн газар олгосон.<br><br>-Хутаг-Өндөр ЭМТөв нь 1 мэс заслын их эмч төрийн албан хаагчийн орон сууцанд амьдардаг. Одоо 8 айлын хаус шинээр баригдаж байгаа бөгөөд түүний нэгд нь УАУ-ы эмчийг оруулахаар төлөвлөсөн.<br>Хамт олны хүчээр мөн зарим иргэдийн хандив тусламжаар өрх толгойлсон 1 ажилтны байшинг гадна дотроос нь дулаалж бүрэн шинэчлэн засварлаж дуусгасан. Үүнд 11 сая төгрөг зарцуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Хангал сумын ЭМТ-д Шинээр ажилд орсон ээлжийн 3 сувилагчид ЗДТГазраас төрийн албан хаагчийн байрыг өгч амьдрах таатай орчноор хангасан. Ерөнхий боловсролын сургуулиас эрүүл мэндийн төвд хүнсний дэмжлэг өгсөн.<br>-Хялганат тосгоны төрийн албан хаагчдын 6 айлын орон сууцанд ЭМТ-өөс 3 жилийн гэрээ хийж 2 их эмч, 1 сувилагчийг амьдрах орчиноор хангасан.<br>-Сайхан сумын ЭМТ-ийн 2 гэр бүл буюу 4 албан хаагчийг орон сууцаар хангасан. | |
| | | | Эрүүл мэндийн салбарын албан хаагч | 10 | 20 | Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор 20 албан хаагчдад зуслангийн газар олгох, 28 ажилтанд өвлийн идэш олгох, амьдрах байраар хангах, орон байрны түрээс, цахилгаан дулааны төлбөр төлөх зэрэг бодит дэмжлэг үзүүлж, 419 албан хаагчдыг урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт хамруулсан. | |
| | | | Зарцуулсан хөрөнгө | 7,3 | 40 | "Гадаад сургалт, туршлага солилцох сургалтад хамрагдсан 6 ажилтанд 8.3 сая, дотоодын сургалтад хамрагдсан 4 ажилтанд 929.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>1 их эмчийн байрны түрээсийн зардалд 900.0 мянга, 3 ажилтны амьдрах байрны дулаан, цахилгааны зардалд 3.1 сая төгрөг зарцуулсан.<br>АНЭ, Рашаант, Хялганат тосгоны ЭМТ-ийн 255 ажилтанд 326.8 сая төгрөгийн 1 сарын үндсэн цалин олгож, нийт 340.0 сая төгрөг зарцуулсан.<br>Мөн тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж гүйцэтгэлээр 847,2 сая, орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 484,8 сая төгрөгийн тэтгэмж тус | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тус олгогдсон. | |
| 1.5 | Салбарын сайдтай байгуулсан гэрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | |
| 1.5.1 | Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх. | | Хэрэгжилтийн хувь | Хэрэгжилтийн хувь-94 | Хэрэгжилтийн хувь 96 | Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээний 2025 оны ажлын төлөвлөгөөг 8 зорилт 60 арга хэмжээний хүрээнд төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. төлөвлөгөөний хэрэгжилт 96%.<br>Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 11 сард 10 төрлийн 238 халдварт өвчний тохиолдол бүртгэгдсэн нь 10,000 хүн амд 39,6 промиль байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 95 тохиолдлоор буурсан үзүүлэлтэй байна.<br>Аймгийн хэмжээнд томуу томуу төст өвчин болон коронавирусын халдварыг 7 хоног тутам харуулдан тандалтын нэгжүүдээр, бусад халдварт өвчний тандалтыг эрт сэрэмжүүлэх хариу арга хэмжээний тогтолцоогоор тус тус дамжуулан тандалтын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байна<br>Халдварт өвчний чиглэлээр эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадваржуулах цахим сургалтыг 8 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 368 эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан.<br>Иргэд олон нийтэд чиглэсэн халдварт өвчнөөс сэргийлэх сургалтыг 6 удаа зохион байгуулж, 124 иргэнийг, сурталчилгааг 39 удаа хийж, 874 иргэнийг тус тус хамруулсан.<br>Эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудсаар халдварт өвчнөөс сэргийлэх талаарх 8 төрлийн зурагт хуудас, анхааруулга, мэдээлэл зөвлөмжийг 38 удаа түгээсэн.<br>Заавал хийх дархлаажуулалтын хамралт 97,6%-тай байна. | 100 |
| 1.5.2 | Шинэ болон сэргэж буй халдварт өвчнөөс | | Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц хангалтын хувь | Эм, эмнэлгийн | Эм, эмнэлгийн хэрэгслийн | Аймгийн хэмжээнд халдварт өвчний тандалтыг эрт сэрэмжлүүлэх хариу арга | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
